



**УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

ТББ-ЫН ЛОГО

**УУЛ УУРХАЙ ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ, ТББ-ЫН ХООРОНД БАЙГУУЛСАН
ГЕОЛОГИЙН САЛБАРЫН МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТНИЙ ЭРХ ОЛГОХ
АСУУДЛЫГ МЭРГЭЖЛИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ
ГЭРЭЭ**

Улаанбаатар хот
2021 он

ГЕОЛОГИЙН САЛБАРЫН МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТНИЙ
ЭРХ ОЛГОХ АСУУДЛЫГ МЭРГЭЖЛИЙН ТӨРИЙН
БУС БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ

2021 оны 03 дугаар
сарын-ны өдөр

Дугаар:

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам /цаашид “яам” гэх/, нөгөө талаас ТББ /цаашид ТББ гэх/ нар харилцан тохиролцож, Ашигт малтмалын тухай хуулийн 10-р зүйлийн 10.1.16, Захиргааны ерөнхий хуулийн 52 дугаар зүйлийн 52.2.2 зүйлийг тус тус үндэслэн байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр Ашигт малтмалын тухай хуулийн 10-р зүйлийн 10.1.16 дахь заалтыг үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А-341 дүгээр тушаалаар батлагдсан “Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам” /цаашид журам гэх/-ын хэрэгжилтийг ТББ-аар гүйцэтгүүлж, Яам нэгдсэн бодлогоор хангаж, хяналт тавин ажиллах харилцааг зохицуулна.
- 1.2. ТББ нь зөвхөн журмын хоёрт тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх ба Яам нь бусад аливаа эрхийг ТББ-д шилжүүлээгүй, давуу эрх олгохгүй болохыг үүгээр баталгаажуулав.
- 1.3. Энэхүү гэрээний хүрээнд Гэрээний хоёрт заасан чиглэлээр геологийн салбарын мэргэшсэн мэргэжилтнийг бэлтгэх сургалт зохион байгуулах, эрх олгох, олгосон эрхийг сунгах, түдгэлзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

ХОЁР. МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭХ
МЭРГЭЖЛИЙН ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

- 2.1 Геологийн салбарын мэргэжлийн чиглэлээр:
 - 2.1.1 Геологи /геологи, тектоник, минерагени, металлогени, магматизм, палеонтологи, геохими, геофизик, геоморфологи, дөрөвдөгчийн геологи, ньютектоник буюу шинэхэн тектоник, гидрогеологи, минералоги, петрологи, петрохими, геотермийн региональ судалгаа ба гадаргуугийн ба гүний том, дунд, жижиг масштабын геологийн бүх төрлийн зураглал болон тэдгээртэй адилтгах бусад геологийн судалгааны чиглэлээр/;
 - 2.1.2 Эрэл-хайгуул /ашигт малтмалын төрлөөр эрэл ба хайгуул, ордын гидрогеологи, ордын инженер-геологи буюу геотехник, ашиглалтын хайгуул, математик-статистик аргачлал болон тэдгээртэй адилтгах бусад чиглэлээр/;

- 2.1.3 Геофизик /бүх төрлийн цахилгаан, соронзон орны, хүндийн хүчний, цооногийн, чичирхийллийн, спектометрийн, агаарын цогцолбор судалгаа болон тэдгээртэй адилтгах бусад геофизикийн судалгааны чиглэлээр/;
- 2.1.4 Геоэкологи болон бусад/ геоэкологи, гео-орчин, гео-гамшиг, инженер геологи, гидрогеологи болон тэдгээртэй адилтгах бусад судалгааны чиглэлээр/;
- 2.1.5 Геологийн салбарын менежмент /геологийн салбарын эдийн засаг, менежмент, аудит, мониторинг болон тэдгээртэй адилтгах бусад геологийн салбарын удирдлага, эдийн засаг, санхүүгийн судалгааны чиглэлээр/;
- 2.1.6 Өрөмдлөг /цохилтод, эргэлтэд, хийн, газрын тосны өрөмдлөг болон тэдгээртэй адилтгах бусад өрөмдлөгийн чиглэлээр/.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 3.1 Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш **3** /гурав/ жилийн хугацаанд хүчинтэй байна.
- 3.2 ТББ нь энэхүү гэрээс дуусахаар 90 /ер/ хоногийн өмнө гэрээ сунгуулах хүсэлтээ Яаманд хүргүүлэх ба ТББ-ын ажлын тайлан, гүйцэтгэл, үйл ажиллагаанд хийсэн дүгнэлт зэргийг үндэслэн сунгах эсэхийг Яам шийдвэрлэнэ.

ДӨРӨВ. ЯАМНЫ ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Энэхүү гэрээний хүрээнд Яам дараах эрхийг хэрэгжүүлнэ:
 - 4.1.1 Гэрээгээр гүйцэтгүүлж буй чиг үүргүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм журмуудын шинэчлэлийн ажлыг шуурхай зохион байгуулж, эрх зүйн орчинг бүрдүүлэн, арга зүйн удирдлагаар хангах;
 - 4.1.2 Мэргэшсэн мэргэжилтний эрхийг олгох, сунгах асуудлыг ТББ-тай хамтран баталгаажуулж мэргэжлийн гэрчилгээ, батламжийг олгох;
 - 4.1.3 Гэрээгээр гүйцэтгүүлж буй чиг үүргүүдийн хэрэгжилтэд нэгдсэн хяналт тавьж, үйл ажиллагааны тайланг шаардаж, ирүүлсэн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг хүргүүлэн, биелэлтийг эргэн шаардах;
 - 4.1.4 ТББ нь гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй буюу гэрээний хэрэгжилт **75** хувиас доогуур биелүүлсэн эсхүл цаашид биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд Яамны санаачлагаар гэрээг дангаар цуцлах /Гэрээний хэрэгжилтийг төрийн бус байгууллагын ирүүлсэн жил бүрийн тайлангийн хэрэгжилтэд яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын хийсэн үнэлгээгээр тооцно/;
 - 4.1.5 Мэргэшсэн мэргэжилтэн нь үүргээ хангалтгүй биелүүлсэн, худал санал, дүгнэлт болон ашиг сонирхлын зөрчилтэй санал, дүгнэлт, тайлан гаргасан нь баримтаар нотлогдсон тохиолдолд түүний эрхийг хүчингүй болгох эсэхийг ТББ-тай хамтран шийдвэрлэнэ.

- 4.1.6 ТББ-ын төлөвлөгөөг жил бүр баталж, үр дүнг тооцон, тайланг дүгнэж ажиллана.
- 4.1.7 Хуулиар олгосон бусад эрхийг эдэлнэ.
- 4.2 Яам дараах үүргийг хүлээнэ:
 - 4.2.1 ТББ-ын үйл ажиллагааг хөндлөнгөөс нөлөөлөхгүй байх, хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах нөхцөл, боломжоор хангах;
 - 4.2.2 Геологийн салбарын мэргэжлийн чиглэл тус бүрээр мэргэшсэн мэргэжилтний мэргэшлийн зэрэг олгох сургалтын хөтөлбөр боловсруулах, шалгалт авах, мэргэшсэн мэргэжилтний эрх олгох талаар санал өгөх мэргэшсэн мэргэжилтний зөвлөлд 3 /гурав/-аас доошгүй төлөөлөл оролцуулна;
 - 4.2.3 Мэргэшлийн зэрэг олгох сургалтын хөтөлбөрийг ТББ-тай хамтран батлана;
 - 4.2.4 Хуулиар олгосон бусад үүргийг хүлээнэ.

ТАВ. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1 Энэхүү гэрээний хүрээнд ТББ дараах эрхийг хэрэгжүүлнэ:
 - 5.1.1 Ашигт малтмалын тухай хуулийн 10-р зүйлийн 10.1.16 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллана; /Энэхүү гэрээний нэгдүгээр зүйлд -д тусгасан/
 - 5.1.2 Гэрээгээр хэрэгжүүлэх чиг үүргүүдийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмуудад нийцүүлэн зохион байгуулна;
 - 5.1.3 Мэргэшсэн мэргэжилтний эрхийг олгох, сунгах асуудлыг Яамтай хамтран баталгаажуулж мэргэжлийн гэрчилгээ, батламжийг олгоно;
 - 5.1.4 Мэргэшсэн мэргэжилтний зөвлөл, Ёс зүйн хороо болон түүнтэй адилтгах эрх бүхий нэгж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл, Яамны саналыг үндэслэн мэргэшлийн зэргийг хүчингүй болгож цуцална ;
 - 5.1.5 Мэргэшсэн мэргэжилтэн нь өөрийн үүргийг хангалтгүй биелүүлсэн тухай ТББ болон яаманд гаргасан гомдол нь ноцтой биш тохиолдолд тухайн мэргэшсэн мэргэжилтний эрхийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлж болно. Түдгэлзүүлэх хугацааны асуудлыг ТББ-ын Ёс зүйн хороо буюу түүнтэй адилтгах нэгжийн саналыг үндэслэн шийдвэрлэнэ.
 - 5.1.6 Мэргэшсэн мэргэжилтний сургалтын төлбөрийг захиран зарцуулах;
 - 5.1.7 Хуулиар олгосон бусад эрхийг эдэлнэ;
- 5.2 ТББ дараах үүргийг хүлээнэ:
 - 5.2.1 Геологийн салбарын мэргэшлийн зэрэг олгох, сунгах, хүчингүй болгох үйл ажиллагаа болон сургалтыг зохион байгуулна;
 - 5.2.2 Мэргэшлийн зэрэг олгох сургалтын хөтөлбөрийг Яамтай хамтран батална;
 - 5.2.3 Батлагдсан хөтөлбөрийн дагуу холбогдох сургалтын байгууллагатай хамтран танхимын хэлбэрээр явуулах бөгөөд үүнтэй дүйцэхүйц эрдэм шинжилгээний хурал, семинар болон бусад хэлбэрээр зохион байгуулж болно;

- 5.2.4 Мэргэшлийн зэрэг горилогчийг сургалтад хамруулах бөгөөд сургалтын төлбөрийн хэмжээг Яамтай зөвшилцөн тогтооно;
- 5.2.5 Мэргэшлийн зэрэг олгох, сунгах, хүчингүй болгох, түдгэлзүүлэх хүрээнд гаргасан шийдвэрээ тухай бүр Яаманд бичгээр мэдэгдэнэ;
- 5.2.6 Үйл ажиллагаа, холбогдох тайлан болон мэргэшсэн мэргэжилтний мэдээллийг ил тод нээлттэй байлгана;
- 5.2.7 ТББ нь тухайн оны холбогдох нэгдсэн тайлан мэдээллийг дараа оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Яаманд хүргүүлнэ;
- 5.2.8 ТББ нь геологийн салбарын мэргэшсэн мэргэжилтний мэдээллийн нэгдсэн тоо бүртгэлийг хөтөлнө;
- 5.2.9 Геологийн салбарын мэргэшсэн мэргэжилтний тоо бүртгэлд өөрчлөлт орох бүрд Яаманд мэдээлэл ирүүлнэ;
- 5.2.10 Сургалттай холбоотой гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч шалгаж шийдвэрлэнэ. Энэ тухай яаманд тухай бүр мэдэгдэнэ;
- 5.2.11 Хуулиар олгосон бусад үүргийг хүлээнэ.

ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА, ДУУСГАВАР БОЛГОХ ҮНДЭСЛЭЛ

- 6.1 ТББ нь шилжүүлэн авсан эрхийг хэрэгжүүлснээс үүсэх үр дагаврыг бүрэн хариуцна.
- 6.2 Гэрээний хугацаа дууссанаар гэрээ дуусгавар болно.
- 6.3 Талууд харилцан тохиролцсоноор гэрээг хугацааны өмнө дуусгавар болгож болно.
- 6.4 Дараах тохиолдолд Яам гэрээний хугацаа дуусахаас өмнө дангаар гэрээг цуцлах эрхтэй ба бичгээр мэдэгдэнэ.
 - 6.4.1 ТББ нь хуурамчаар материал бүрдүүлэн эрх олгосон;
 - 6.4.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй;
 - 6.4.3 тухайн төрийн бус байгууллага нь эрх зүйн чадамжгүй болсон;
 - 6.4.4 Төрийн бус байгууллагад гэрээгээр шилжүүлсэн эрх, үүрэг буюу энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотойгоор удаа дараа гомдол гарсан ба уг гомдол нь үндэслэлтэй болох нь баримтаар нотлогдсон эсхүл УУХҮЯ-ны шалгалтын дүнгээр хангалтгүй дүн авсан бол.
- 6.5 Талуудын хооронд энэхүү гэрээтэй холбоотой маргаан үүсэн тохиолдолд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ. Хэрвээ тохиролцоонд хүрч чадаагүй бол Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

ДОЛОО. БУСАД ЗҮЙЛ

- 7.1 Талууд гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн энэхүү гэрээ нь хүчин төгөлдөр болно.
- 7.2 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах бол талууд саналаа бичгээр гаргана. Санал гаргагч тал саналаа 10 /арав/-аас доошгүй хоногийн өмнө нөгөө талд албан бичгээр, энэхүү гэрээнд заасан хаягаар хүргүүлнэ.
- 7.3 Монгол Улсын Гамшгийн тухай хууль тогтоомжоор давагдашгүй хүчин зүйл үйлчилж эхэлсэн тухай бүрт давагдашгүй хүчин зүйлийн үргэлжилсэн

хугацаагаар гэрээний үйлчлэлийг сунгах бөгөөд талууд энэ тухай бичгээр бие биедээ мэдэгдсэн байна.

- 7.4 Хэрвээ давагдашгүй хүчин зүйлийн үйлчилж буй үед зайнаас буюу цахим хэлбэрээр сургалт явуулах тохиолдолд талууд харилцан тохиролцож сургалт явуулах арга, хэлбэрийг тогтоосны үндсэн дээр сургалтыг зохион байгуулж болно.
- 7.5 Гэрээг 3 /гурав/ хувь үйлдэж, яам 2 /хоёр/ хувь, төрийн бус байгууллага 1 /нэг/ хувийг тус тус талууд хадгалах бөгөөд хувиуд адил тэгш хүчинтэй.
- 7.6 Талууд хаяг өөрчлөгдсөн тухай бүр энэ тухай нөгөө талдаа мэдэгдэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

УУХҮЯ-ыг төлөөлж Төрийн нарийн бичгийн дарга ТББ-ыг төлөөлж
Г.Нандинжаргал

Хаяг: Нэгдсэн Үндэстний гудамж, Засгийн газрын II байр. Хаяг:

Утас: 51-263506 Утас:

Цахим шуудан: info@mmhi.gov.mn Цахим шуудан:

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД

[Төрийн бус байгууллагын нэр] нь Геологийн салбарын мэргэшсэн мэргэжилтний эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээний нөхцлийг бүхэлд нь хүлээн зөвшөөрч байна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Төрийн бус байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Төрийн бус байгууллагын тамга:

Огноо:

Хаяг: